



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 8/311

Булган сум


Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14 дүгээр хуралдааны XIV/01 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 106 дугаар байрны дээврийн засварын ажлыг 16,330,000 (арван зургаан сая гурван зуун гучин мянга) төгрөгт багтаан хууль, журмын дагуу зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хяналт тавьж ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

2.Санхүүжилтийг Байгаль орчныг хамгаалах, баялгийг нөхөн сэргээх сангийн "Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах" арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ